



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 9/28

Улаанбаатар хот

Үндэсний аудитын газрын бүтэц,
зохион байгуулалт, бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг,
үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.4.6, 13.4.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын бүтэц, зохион байгуулалтыг нэгдүгээр хавсралтаар, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар, орон тоо, албан тушаалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Үндэсний аудитын газрын бүтцийн нэгж, түүний чиг үүрэг, орон тоо, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг газар, нэгжийн удирдлагуудын оролцоотойгоор 2017 оны 04 дүгээр сарын 7-ны өдрийн дотор шинэчлэн боловсруулж, батлуулахыг Тамгын газар /Ц.Ганболд/-т үүрэг болгосугай.

3. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн "Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, нэгжүүдийн чиг үүрэг, албан тушаалын жагсаалтыг батлах тухай" 04 дүгээр тушаал, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Төрийн аудитын байгууллагын орон тооны хуваарь батлах тухай" 318 дугаар тушаалыг тус тус 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болсонд тооцож, мөн өдрөөс эхлэн энэхүү тушаалыг мөрдеж ажилласугай.

4. Энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.


МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР



Монгол Улсын Ерөнхий Аудиторын
2017 оны дугаар сарын 24-ны
өдрийн дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Монгол Улсын Ерөнхий Аудиторын
2017 оны дугаар сарын 11-ны
өдрийн дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН БУТЦИЙН НЭГЖҮХДИЙН
ҮНДСЭН ЧИГҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг. Удирдлагын зөвлөл

Монгол Улсын Ерөнхий аудиторыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж, зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус бүрэлдэхүүнтэй Удирдлагын зөвлөл Үндэсний аудитын газар (ҮАГ)-т ажиллана.

ҮАГ-ын Удирдлагын зөвлөл нь Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч, Тамгын газрын дарга, Дотоод аudit, чанарын баталгаажуулалтын албаны дарга, Гүйцэтгэлийн, Нийцлийн болон Санхүүгийн аудитын газрын захирал, Хууль, эрх зүйн хэлтсийн даргаас бүрдэхээс гадна орон тооны бус нарийн бичгийн даргатай байна. Удирдлагын зөвлөлийн нарийн бичгийн даргыг Ерөнхий аудиторын тушаалаар томилж, чөлөөлнө.

Удирдлагын зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, Ерөнхий аудиторт санал өгч, зөвлөнө. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын урт болон дунд хугацааны бодлого, стратеги тэдгээрийн хэрэгжилт, гүйцэтгэл болон үр дүн;
- Төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудаас хийх аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, түүний хэрэгжилт, гүйцэтгэл болон тайлан, үр дүн;
- Төрийн аудитын байгууллагын болон Үндэсний аудитын газрын үйл ажиллагааны хэтийн болон жилийн төлөвлөгөө, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, гүйцэтгэл болон үр дүн;
- Төрийн аудитын бодлого, арга зүй, стандарт, журам, аргачлал, заавар, зааварчилгаа;
- Төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, бүрэлдэхүүн;
- Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бодлого, сургалт хөгжүүлэлт, нийгмийн асуудал;
- Төрийн аудитын байгууллагын төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, гүйцэтгэл болон тайлан;
- Төрийн аудитын байгууллагад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн бодлого, чиглэл, тэдгээрийн хэрэгжилт, гүйцэтгэл ба үр дүн;
- Ерөнхий аудиторын хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бусад асуудал.

Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхий аудитор Удирдлагын зөвлөлийг өргөтгөсөн бүрэлдэхүүн (Ерөнхий аудиторын зөвлөх, Ерөнхий аудиторын орон тооны бус зөвлөх, тэргүүлэх аудитор, хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн)-тэй хуралдуулна.

Удирдлагын зөвлөлийн ажиллах журам, хэлэлцэх асуудал, хурлын дэгийг Ерөнхий аудитор батална.

Хоёр. Ёс зүйн зөвлөл

ҮАГ-т төрийн аудитын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн зөрчлийг шалгаж, дүгнэлт гаргах

үндсэн чиг үүрэг бүхий Ерөнхий аудиторт зөвлөх эрхтэй, орон тооны бус бүрэлдэхүүнтэй Ёс зүйн зөвлөл ажиллана.

Ёс зүйн зөвлөл нь орон тооны бус 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг Ерөнхий аудитор томилж, чөлөөлнө.

Ёс зүйн зөвлөл нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийг шинэчлэх, боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;
- Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийн мөрөөр шалгалт хийж, дүгнэлт гаргах;
- Төрийн аудитын байгууллагын ажилтнуудад ёс зүйн сургалт явуулах;
- Бусад;

Ёс зүйн зөвлөлийн эрх үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан журмыг Ерөнхий аудитор батална.

Гурав. Ерөнхий аудиторын зөвлөх

Монгол Улсын Ерөнхий аудиторт хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, төрийн аудитын бодлого, стратеги, хөгжлийн асуудлаар бодлогын зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэгтэй Зөвлөх ажиллана.

Ерөнхий аудиторт өгөх бодлогын зөвлөгөө нь төрийн аудитын үйл ажиллагааны суурь зарчим, стандарт, онол, арга зүй болон олон улсын шилдэг туршлага, хөгжлийн хэтийн хандлагыг баримталж, мэргэжлийн судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байна.

Зөвлөх нь Ерөнхий аудитороос өгсөн чиглэл, удирдамжийн хүрээнд төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох арга зүйн дагуу нягтлан шалгаж, зөвлөгөө, мэдээллээр хангана.

Дөрөв. Дотоод аудит, чанарын баталгаажуулалтын алба

Дотоод аудит, чанарын баталгаажуулалтын алба нь дотоод аудитын болон аудитын чанарын баталгаажуулалтын үндсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дотоод аудит, чанарын баталгаажуулалтын алба нь үйл ажиллагаанд мэргэжлийн болон ёс зүйн холбогдох стандарт, дүрмийг баримталж ажиллана.

- Дотоод аудитын чиг үүргийн хүрээнд тус алба нь төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, өгсөн үүрэг даалгаврын дагуу хараат бусаар дотоод аудит хийж, дүгнэлт, санал бэлтгэх бөгөөд дүнг Ерөнхий аудиторт шууд тайлагнана.

Дотоод аудит хийх сэдэв, төлөвлөгөөг Ерөнхий аудитор батална.

- Аудитын чанарын баталгаажуулалтын чиг үүргийн хүрээнд тус алба нь төрийн аудитын бодлого, арга зүй, аудитын чанарын хяналт, аудитын удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагаа, аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын аудитын төлөвлөлт, зохион байгуулалт болон гүйцэтгэл, түүний үр дүн, үр нөлөөт байдалд хараат бусаар чанарын баталгаажуулалт хийж, сайжруулах санал зөвлөмжөөр хангана.

Аудитын чанарын баталгаажуулалт хийх сэдэв, төлөвлөгөөг Ерөнхий аудитор батална.

Дотоод аудит, чанарын баталгаажуулалтын алба нь Ерөнхий аудиторын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой асуудлаар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд шалгагдагч байгууллагад аудит хийж, дүгнэлт, тайлан бэлтгэнэ.

Ерөнхий аудитор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дотоод аудитын болон аудитын чанарын баталгаажуулалтын дүнг ЯАГ-ын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх болон төрийн аудитын үйл ажиллагаанд аудитын чанарын баталгаажуулалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулсан дурэм, журмуудыг Ерөнхий аудитор батална.

Тав. Ерөнхий аудиторын төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг хариуцсан орлогч бөгөөд тэргүүлэх аудитор

Ерөнхий аудиторын шууд удирдлага дор төрийн аудитын мэргэжил, арга зүйн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудын асуудлыг эрхлэх чиг үүрэг бүхий тэргүүлэх аудитор зэрэглэлтэй орлогч ажиллана.

Тус орлогч нь Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон ЯАГ-ын аудит хийх бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд Ерөнхий аудиторт туслалцаа үзүүлнэ.

Ерөнхий аудиторын орлогчийн шууд удирдлага дор Гүйцэтгэлийн, Нийцлийн, Санхүүгийн аудитын газар болон Бодлого, төлөвлөлтийн газар ажиллана.

Ерөнхий аудиторын орлогчид зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус бүрэлдэхүүнтэй Аудитын зөвлөл ажиллана.

Ерөнхий аудиторын төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг хариуцсан орлогч нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын ерөнхий удирдлагаар хангах;
- Төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудын аудит хийх жилийн төлөвлөгөө, хуваарийг хянаж, Ерөнхий аудиторт өргөн мэдүүлэх;
- Аудитын зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжид үндэслэн аудитын төлөвлөгөө болон аудитын тайлангийн төслийг Ерөнхий аудиторт өргөн мэдүүлэх эсэхийг шийдвэрлэх;
- Төрийн аудитын байгууллагын аудитын бодлого, стандарт, арга зүй, журам, заавар, аргачлалыг шинээр боловсруулах, шинэчлэх, өөрчлөх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;
- Төрийн аудитын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг төрийн аудитын үйл ажиллагаатай уялдуулан удирдлага, зохицуулалтаар хангах;
- Нэгдсэн удирдамжаар хийх аудитад төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын ерөнхий удирдлагаар хангах;
- Хууль тогтоомжоор олгогдсон болон Ерөнхий аудитороос шилжүүлсэн бусад эрх, үүрэг.

**Зургаа. Ерөнхий аудиторын төрийн аудитын орон нутаг дахь салбар
байгууллагуудыг хариуцсан орлогч бөгөөд тэргүүлэх аудитор**

Ерөнхий аудиторын шууд удирдлага дор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын асуудлыг эрхэлсэн, тэргүүлэх аудитор зэрэглэлтэй орлогч ажиллаж, Ерөнхий аудиторын эрх шилжүүлсний дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Тус орлогч нь Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын аudit хийх бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд Ерөнхий аудиторт туслалцаа үзүүлнэ.

Ерөнхий аудиторын орлогчид зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус бүрэлдэхүүнтэй Аудитын зөвлөл ажиллана.

Ерөнхий аудиторын орлогч нь төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэн удирдаж, дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ УАГ болон төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудаас төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудтай харилцах харилцааг уялдуулан зохицуулна.

Тус орлогчийн шууд удирдлагад аймаг, нийслэл дэх төрийн аудитын салбар байгууллагууд болон Ажлын алба, Сургалт, хөгжүүлэлтийн төв ажиллана.

Эдгээр байгууллага, албадын гүйцэтгэх дараах үндсэн чиг үүргийг удирдан, зохион байгуулах хүрээнд Ерөнхий аудиторын орлогч нь дор дурдсан болон Ерөнхий аудитороос шилжүүлсэн бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллагын эрхлэх асуудлын тухайд:
 - Хууль тогтоомжид заасан болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой асуудлаар гүйцэтгэлийн, санхүүгийн тайлангийн болон нийцлийн аudit хийж, дүгнэлт гаргах;
 - Төрийн аудитын тухай хуулиар тогтоосон өөрийн бүрэн эрхийн хүрээнд хийх аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх, дүгнэлт, тайланг бэлтгэх;
 - Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийх аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж, дүгнэлт, тайланг холбогдох журмын дагуу бэлтгэж, хүргүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөнд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах аудитын сэдвийн чиглэлээр санал өгөх;
 - Орон нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланд аudit хийх;
 - Орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аudit хийх;
 - Орон нутгийн төсвийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх;
 - Орон нутгийн төсвийн төсөлд санал боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах;
 - Холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон шаардлагуудыг хэрэгжүүлж, аудитын стандарт, журам, арга зүйг мөрдөж ажиллахын зэрэгцээ сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;
 - Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын цахим хуудсыг боловсруулах, хөгжүүлэх, найдвартай, аюулгүй, байнгын ажиллагааг хангах;
 - Аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр санхүүгийн тайлангийн аudit хийлгэх орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчйт болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт бэлтгэж, шийдвэрлүүлэх;
 - Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэх санхүүгийн тайлангийн аудитын гэрээний төслийг боловсруулах, батлуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

- Гэрээний үндсэн дээр аудитын бусад байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт тавьж, баталгаажуулах;
 - Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтын дагуу санхүүгийн тайланд нь жил бүр аudit хийх шаардлагагүй байгууллагын судалгаа хийж, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;
 - Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;
 - Төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
 - Гүйцэтгэсэн аудитын үр дүнг холбогдох байгууллага, олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх;
 - Аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнг тайлагнах;
 - Өөрийн бүрэн эрхэд хамаарах хүрээний асуудлаар болон гүйцэтгэсэн аудитын үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох талыг мэдээллээр хангах;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг;
- Ажлын албаны эрхлэх асуудлын тухайд:
 - Төрийн аудитын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох журам, зааврыг боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох;
 - Төрийн аудитын байгууллагын төсвийг төлөвлөх, төсвийн хязгаарын санал боловсруулах, төсвийн төслийн санал бэлтгэх;
 - Төрийн аудитын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон Үндэсний аудитын газар, орон нутаг дахь салбар байгууллагын төсвийн эрх нээлгэх, санхүүжилтийг хуваарилах;
 - Төрийн аудитын байгууллагын төсвийн зарцуулалт, үр дүн, гүйцэтгэлийн талаар сар, улирал, жилийн нэгдсэн тайлан мэдээ боловсруулах;
 - Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон бүтээгдэхүүний өртөг, зардлын судалгаа, тооцоолол хийх;
 - Төрийн аудитын байгууллагын хөрөнгө оруулалтын төсвийг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;
 - Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагааг удирдан, чиглүүлэх, хяналт тавих;
 - Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ бэлтгэх, нэгтгэх;
 - Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын өмч хөрөнгө, бараа материалын хангамжийг зохион байгуулах;
 - Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг тооцож олгох, нийгмийн даатгалын болон орлогын татварын суутгал, тооцоо хийх;
 - Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллагын биет болон биет бус хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын хэтийн болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэх, нэгдсэн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах;

- Төрийн аудитын байгууллагын болон төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын улирал, жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэх, нэгдсэн тайлан бэлтгэх;
 - Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны улирал, жилийн статистик судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд мониторинг, дүн шинжилгээ хийх;
 - Төрийн аудитын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах, зохицуулалтаар хангах;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх тус нэгжийн бусад ажил үүрэг;
- Сургалт, хөгжүүлэлтийн төвийн эрхлэх асуудлын тухайд:
 - Төрийн аудитын байгууллагын хэмжээнд зохион байгуулах төвлөрсөн, бүсчилсэн болон сэдэвчилсэн сургалтын жилийн төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийг боловсруулж, батлуулах;
 - Төрийн аудитын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг төрийн аудитын сургалтын бодлого, хөтөлбөртэй уялдуулах, зохицуулалтаар хангах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтны мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
 - Төрийн аудитын олон улсын болон дотоодын төвлөрсөн, бүсчилсэн, сэдэвчилсэн сургалт, семинарыг зохион байгуулалтаар хангах;
 - Сургалтын орчин, материаллаг бааз суурийг бэхжүүлэх, техник технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх тус нэгжийн бусад ажил үүрэг;

Долоо. Тамгын газар

Тус газар нь ЯАГ-ын Тамгын газрын даргын шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулах бөгөөд Үндэсний аудитын газрын захиргааны удирдлагын болон нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

ЯАГ-ын Тамгын газрын дарга нь ЯАГ-ын төсвийн шууд захирагчийн эрх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Ерөнхий аудиторын шууд удирдлага дор ажиллана.

Тамгын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- I. Нийтлэг үйлчилгээний алба
 - II. Хүний нөөцийн алба
 - III. Мэдээллийн технологийн алба
- Нийтлэг үйлчилгээний албаны гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл:
 - Ерөнхий аудиторын тушаал, шийдвэрийн төслийг боловсруулах;
 - Ерөнхий аудиторын баталсан тушаал, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;
 - ЯАГ-ын нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх;
 - ЯАГ-ын биет болон биет бус хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх;
 - ЯАГ-ын төсвийг боловсруулж, батлуулах;
 - ЯАГ-ын төсвийн зарцуулалт, үр дүн, гүйцэтгэлийн сар, улирал, жилийн тайлан мэдээ боловсруулах;
 - ЯАГ-ын ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг тооцож олгох;

- УАГ-ын ажилтны нийгмийн даатгалын болон орлогын татварын суутгал, тооцоо хийх, холбогдох дэвтэр, бүртгэл хөтлөх, баталгаажуулах;
 - Хурал, зөвлөгөөн, ёслол хүндэтгэл, хамт олны болон олон нийтийн ажлыг зохион байгуулах;
 - Төрийн аудитын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд мэдээлэх, эргэх холбоо бий болгох;
 - Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах, бүртгэх, шийдвэрлүүлэх санал бэлтгэх;
 - Төрийн аудитын байгууллагын бичиг хэрэг, архивын үйл ажиллагааг эрхлэн явуулах;
 - Аж ахуй, хангамжийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
 - Автомашины үйлчилгээг зохицуулах;
 - Худалдан авалт, тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулах;
 - Аудитын дээд байгууллагуудын олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай харилцаа холбоо хөгжүүлэх, төрийн аудитын байгууллагыг тэдгээрийн тусламж дэмжлэгт хамруулах;
 - Бусад улс, орны аудитын дээд байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнуудад шаардлагатай албан хэргийн аман болон бичгийн орчуулга хийх;
 - Гадаад улс оронд зохион байгууллагдах сургалт, арга хэмжээнд хамрагдах ажилтнуудын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллага, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, гадаад хэл дээрх цахим хуудсыг агуулгыг боловсруулах;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.
- Хүний нөөцийн албаны гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл:
 - Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бодлого, холбогдох журам, зааврыг боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох;
 - Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагад анх орох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтны судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын албан тушаалын ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэг боловсруулах ажлыг зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтны цалин, зэрэг дэв, шагнал урамшуулал, тусламж, дэмжлэг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтныг мэргэшүүлэх, хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалт, арга хэмжээнд хамруулах санал боловсруулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх үйл ажиллагааг төрийн аудитын байгууллагын хэмжээнд зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг төрийн болон салбарын шагналд тодорхойлоход санал боловсруулах;
 - Төрийн аудитын байгууллагад ажиллаж байсан ахмад ажилтнуудын нэгдсэн судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрийг хамарсан олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээ авах эмнэлгийн байгууллагад харьяалуулах асуудлыг зохион байгуулах;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

- Мэдээллийн технологийн албаны гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл:
 - Төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн бодлого, холбогдох журам, зааврыг боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох;
 - Төрийн аудитын байгууллагын цахим хуудас, цахим шуудан, харилцаа холбооны системийг боловсруулах, хөгжүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын гадаад, дотоод цахим сүлжээ, харилцаа холбоо, цахим шуудангийн системийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах;
 - Төрийн аудитын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололт, шийдэл, шилдэг туршлагыг нэвтрүүлэх;
 - Мэдээллийн системийн үйл ажиллагаанд хяналт тавих, өөрчлөлт, шинэчлэлт, хөгжүүлэлтийг тухай бүр хийж байх;
 - Мэдээллийн сангийн нууцпал, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, нөөц үүсгэх;
 - Компьютер болон бусад техник хэрэгслийн найдвартай, хэвийн ажиллагааг хангах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнуудад компьютер, техник хэрэгсэл болон программуудыг ашиглахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
 - Аудитын үйл ажиллагаа болон бусад чиглэлээр ашиглах программ хангамжийг нэвтрүүлэх, шинэчлэх, өөрчлөх, хөгжүүлэх, боловсронгуй болгох;
 - Хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлэх, олшруулах;
 - Цахим материал бэлтгэх;
 - Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос олгосон эрх, ногдуулсан үүргийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

Найм. Хууль, эрх зүйн хэлтэс

ҮАГ-т Ерөнхий аудиторын удирдлага дор, төрийн аудитын байгууллагад хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, Ерөнхий аудитор төрийн аудитын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх үүргээ биелүүлэхэд нь хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй Хууль, эрх зүйн хэлтэс ажиллана.

Тус хэлтэс дор дурдсан чиглэлийн хүрээнд холбогдох үйл ажиллагааг болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу бусад ажил үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:
 - Хууль санаачлагч субъектээс ирүүлсэн хуулийн төсөл, эрх зүйн бусад баримт бичгийн төсөлд удирдлагаас өгсөн үүргийн дагуу санал бэлтгэж удирдлагад танилцуулах, холбогдох хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийн тэдгээрийг боловсронгуй болгох санал боловсруулж, удирдлагад танилцуулах.
- Эрх зүйн актыг боловсронгуй болгох хүрээнд:
 - Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг удирдлагаас өгсөн үүргийн дагуу судалж, шинэчлэх, боловсронгуй болгох санал боловсруулах;
 - Ерөнхий аудиторын тушаалаар батлах эрх зүйн актын үндэслэлийг хянах, хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагын албан хэрэг хөтлөлтийн заавар боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох;
 - Төрийн аудитын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох.

- Тушаал, шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд:
 - Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, шийдвэрийн төсөл болон бусад удирдлагын шийдвэрийн төслийг удирдлагаас өгсөн үүргийн дагуу хянаж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэх чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.
- Байгууллагын эрх ашгийг хамгаалах хүрээнд:
 - Төрийн аудитын байгууллагын эрх ашгийг хамгаалах зорилгоор удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу шүүх, прокурор, бусад эрх бүхий байгууллагатай харилцах, шүүхэд төлөөлж, хариуцагч, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох;
 - Төрийн аудитын байгууллагаас гаргах акт, албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулахаар эрх бүхий ажилтанд тавих саналын үндэслэлийг хянан үзэх, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
 - Төрийн аудитын байгууллагаас хуулийн байгууллагад шилжүүлсэн акт, албан шаардлагыг бүртгэж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
 - Байгууллагад учирсан аливаа хохирлыг барагдуулах талаар удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хууль, хяналтын байгууллагад хүсэлт, нэхэмжлэл гаргах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд нь хууль зүйн зөвлөгөө өгөх;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнууд ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах;
 - Төрийн аудитын байгууллагын ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хууль, эрх зүйн актыг сурталчлах, мэдээлэл өгөх;
 - Төрийн аудитын байгууллагаас байгуулах гэрээний төслийг хууль тогтоомжид нийцүүлэхэд хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.
- Хууль тогтоомж, эрх зүйн актыг системчлэх хүрээнд:
 - Төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, олон улсын эрх зүйн эх сурвалжийг системчлэн хадгалах, сан бүрдүүлэх, түүнд тогтмол баяжилт хийх.

Ес. Аудитын зөвлөл

- Ерөнхий аудиторын орлогчийн дэргэд орон тооны бус бүрэлдэхүүнтэй УАГ-ын Аудитын зөвлөл ажиллана. Аудитын зөвлөлийн бүрэлдэхүүнд Гүйцэтгэлийн, Нийцлийн, Санхүүгийн аудитын болон Бодлого, төлөвлөлтийн газрын захирал, бусад ажилтнууд орно.
- Аудитын зөвлөл нь Аймаг, Нийслэл дэх төрийн аудитын газар, Гүйцэтгэлийн, Нийцлийн, Санхүүгийн аудитын болон Бодлого, төлөвлөлтийн газрын чиг үүрэгт хамаарах аливаа асуудлыг Ерөнхий аудиторын орлогчоос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хэлэлцэж, санал зөвлөмж гаргана.
- Тус зөвлөл нь шинээр болон шинэчлэн боловсруулсан төрийн аудитын бодлого, стандарт, арга зүй, журам, дүрэм, заавар, зааварчилгаа, гарын авлагын төсөл, аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, Ерөнхий аудиторт өргөн мэдүүлэх эсэх талаар санал, зөвлөмж гаргана.
- Аудитын зөвлөл нь төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагуудаас хийх аудитын хуваарь, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөв, зардлыг хэлэлцэхээс гадна аудитын гүйцэтгэл, чанар, үр дүн, үр нэлөө, холбогдох бусад асуудлыг хэлэлцэж, сайжруулах зөвлөмж өгч, санал боловсруулна.
- Ерөнхий аудиторын төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудаг хариуцсан орлогч болон төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг хариуцсан орлогч нь өөр, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Аудитын зөвлөлийг зарлан хуралдуулна.

- Аудитын зөвлөл, түүний бүрэлдэхүүн, зөвлөлийн гишүүдийн эрх үүрэг, хэлэлцэх асуудал, хамрах хүрээ, хуралдааны дэгийг тогтоосон журмыг Ерөнхий аудитор батална.

Арав. Гүйцэтгэлийн аудитын газар

Гүйцэтгэлийн аудитын газар нь Үндэсний аудитын газрын аudit хийх бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аudit хийж, шалгагдагч байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгаад дүгнэлт, гаргаж, зөвлөмж өгөх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Дээрх үндсэн чиг үүргийн хүрээнд Гүйцэтгэлийн аудитын газар нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөнд гүйцэтгэлийн аудитын сэдвийн чиглэлээр санал өгөх;
- Батлагдсан сэдэв, хуваарийн дагуу хийх гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, дүнг тайлagnaх, үр дүнг үнэлэх;
- Холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт болон гүйцэтгэлийн аудитын чиглэлээр гаргасан аудитын стандарт, журам, арга зүйг мөрдөж ажиллахын зэрэгцээ сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аudit хийх;
- Төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аudit хийх;
- Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр гүйцэтгэлийн аudit хийх;
- Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусlamж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дунд гүйцэтгэлийн аudit хийх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр дунд гүйцэтгэлийн аudit хийх;
- Төрийн өмчийн ашиглалт, зарцуулалтад гүйцэтгэлийн аudit хийж, дүгнэлт гаргах;
- Төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд, түүнчлэн төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аudit хийж дүгнэлт гаргах;
- Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аudit хийх;
- Хууль тогтоомжид заасан болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой асуудлаар гүйцэтгэлийн аudit хийж, дүгнэлт гаргах;
- Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;
- Төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
- Гүйцэтгэлийн аудитын үр дүнг холбогдох байгууллага, олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх;

- Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнг тайлагнах;
- Гүйцэтгэлийн аудитын хамрах хүрээний асуудлаар болон гүйцэтгэлийн аудитын үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох талыг мэдээллээр хангах;
- Батлагдсан сэдвийн дагуу хийх аудитад гадны мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулах санал боловсруулах;
- Нэгдсэн удирдамжаар болон хамтарч хийх гүйцэтгэлийн аудитад төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Аудитын тайлан болон бусад баримт материалыг албан хэрэг хөтлөлтийн заавар, журмын дагуу архивын нэгж болгон, бичиг хэрэг, архивт шилжүүлэх;
- Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

Гүйцэтгэлийн аудитын газар нь дараах 5 албатай байх бөгөөд алба тус бүр ахлах аудитор болон 3 аудитороос бүрдэнэ. Гүйцэтгэлийн аудитын газрын холбогдох албад нь дор дурдсан чиглэлийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийнэ. Үүнд:

- 1) Санхүү, эдийн засгийн аудитын 1 дүгээр алба: Банк, санхүү, даатгал, төсөв, зээл, тусlamж, хөрөнгө оруулалт, өрийн удирдлага, макро эдийн засаг, гааль, татвар болон эдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаа;
- 2) Санхүү, эдийн засгийн аудитын 2 дугаар алба: Банк, санхүү, даатгал, төсөв, зээл, тусlamж, хөрөнгө оруулалт, өрийн удирдлага, макро эдийн засаг, гааль, татвар болон эдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаа;
- 3) Нийгмийн салбарын аудитын алба: Эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүч, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спорт, соёл, урлаг болон эдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаа;
- 4) Үйлдвэр, дэд бүтцийн салбарын аудитын алба: Хөнгөн ба хүнд аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, байгаль орчин, геологи, уул уурхай, эрдэс баялаг, хөдөө аж ахуй, газар тариалан, эрчим хүч, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн технологи, барилга, хот төлөвлөлт, газрын харилцаа, худалдаа үйлчилгээ болон эдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаа;
- 5) Төрийн байгууллагын аудитын алба: Төрийн төв байгууллагууд, төрийн захирагааны байгууллагын эрхлэх, дээрх салбарын ангилалд хамрагдаагүй чиг үүргүүд, батлан хамгаалах, хууль сахиулах, шүүх прокурорын байгууллагууд болон төрийн байгууллагад хамаарах адилтгах бусад үйл ажиллагаа;

Арван нэг. Санхүүгийн аудитын газар

Санхүүгийн аудитын газар нь Үндэсний аудитын газрын аудит хийх бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудит хийж, шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлан, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж, баталгаажуулах үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Дээрх үндсэн чиг үүргийн хүрээнд Санхүүгийн аудитын газар нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөнд санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр санал өгөх;

- Батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу хийх санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, дүнг тайлагнах, үр дүнг үнэлэх;
- Холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт болон санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр гаргасан аудитын стандарт, журам, арга зүйг мөрдөж ажиллахын зэрэгцээ сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;
- Улсын Их Хурал болон бусад төрийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Засгийн газрын тусгай зориулалтын сангудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчид болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайланд тэдний хүсэлтээр аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж, дүгнэлт гарган, баталгаажуулах;
- Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт, уг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан саналын талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж танилцуулах;
- Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;
- Төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
- Санхүүгийн тайлангийн аудитын үр дүнг холбогдох байгууллага, олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх;
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнг тайлагнах;
- Санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээний асуудлаар болон санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох талыг мэдээллээр хангах;
- Аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх төсвийн байгууллага, төрийн өмчтөй болон төрийн өмчтөй хуулийн этгээдийн жагсаалт бэлтгэж, шийдвэрлүүлэх;
- ЯАГ-аас аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэх санхүүгийн тайлангийн аудитын гэрээ байгуулах, батлуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- Гэрээний үндсэн дээр аудитын бусад байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт тавьж, баталгаажуулах;
- Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтын дагуу санхүүгийн тайланд нь жил бүр аудит хийх шаардлагагүй байгууллагын судалгаа хийж, санал боловсруулж, шийдвэрлүүлэх;
- Аудитын тайлан болон бусад баримт материалыг албан хэрэг хөтлөлтийн заавар, журмын дагуу архивын нэгж болгон, бичиг хэрэг, архивт шилжүүлэх;

- Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

Санхүүгийн аудитын газар нь 5 албатай байх бөгөөд алба тус бүр нь ахлах аудитор болон 4 аудитороос бүрдэнэ.

Арван хоёр. Нийцлийн аудитын газар

Нийцлийн аудитын газар нь Үндэсний аудитын газрын аудит хийх бүрэн эрхийн хүрээнд нийцлийн аудит хийж, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагын хэрэгжилтэд дүгнэлт гаргах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэхүү үндсэн чиг үүргийн хүрээнд Нийцлийн аудитын газар нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна.

Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөнд нийцлийн аудитын сэдвийн чиглэлээр санал өгөх;
- Аудит хийх сэдвийн төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэх нийцлийн аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, дүнг тайлагнах, үр дүнг үнэлэх;
- Холбогдох хууль, тогтоомж болон нийцлийн аудитын чиглэлээр гаргасан аудитын стандарт, журам, арга зүйг мөрдөж ажиллахын зэрэгцээ сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нийцлийн аудит хийх;
- Төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нийцлийн аудит хийх;
- Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр нийцлийн аудит хийх;
- Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусlamж, хандивын ашиглалт, зарцуулалтад нийцлийн аудит хийх;
- Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт, уг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан саналын талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж танилцуулах;
- Төрийн өмчийн ашиглалт, зарцуулалтад нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргах;
- Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах;
- Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, сонгуулийн эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах;
- Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн

тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

- Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд болон сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт гаргах;
- Сонгуулийн ерөнхий хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах;
- Төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд, түүнчлэн төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах;
- Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийх;
- Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах.
- Хууль тогтоомжид заасан болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой асуудлаар нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргах;
- Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;
- Төрийн албан хаагч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
- Нийцлийн аудитын үр дүнг холбогдох байгууллага, олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх;
- Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнг тайлгаха;
- Нийцлийн аудитын хамрах хүрээний асуудлаар болон нийцлийн аудитын үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох талыг мэдээллээр хангах;
- Батлагдсан сэдвийн чиглэлээр хийх аудитад гадны мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулах санал боловсруулах;
- Нэгдсэн удирдамжаар болон хамтарч хийх нийцлийн аудитад төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Аудитын тайлан болон бусад баримт материалыг албан хэрэг хөтлөлтийн заавар, журмын дагуу архивын нэгж болгон, бичиг хэрэг, архивт шилжүүлэх;
- Хууль тогтоомжоор хүлээсэн болон Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

Нийцлийн аудитын газар нь 2 албатай байх бөгөөд алба тус бүр нь ахлах аудитор болон 2 аудитороос бүрдэнэ.

Арван гурав. Бодлого, төлөвлөлтийн газар

ҮАГ-ын Бодлого, төлөвлөлтийн газар нь Ерөнхий аудиторын төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг хариуцсан орлогчийн шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулах бөгөөд төрийн аудитын төрөлжсөн болон орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор аудитын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлаар

судалгаа хийж, санал бэлтгэх ба аудитын стандарт, дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ чиг үүргийн хүрээнд тус газар дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагыг хөгжүүлэх бодлогын судалгаа хийж, төрийн аудитын байгууллагын хөгжлийн стратеги, төлөвлөгөө, хөтөлбөрийн санал боловсруулах;
- Төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой олон улсын шилдэг туршлагыг судалж, нэвтрүүлэх;
- Төрийн аудитын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулах;
- Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын үндэсний стандарт боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох;
- Төрийн аудитын үндэсний стандарт болон бусад стандарт, шилдэг туршлагад үндэслэн төрийн аудитын бодлого, арга зүй, журам, зааврыг боловсронгуй болгох;
- Аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулах зорилгоор шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- Аудитын төрөл тус бүрээр хийх аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөний санал боловсруулах;
- Төрийн аудитын байгууллагын ажилтнуудад зориулсан аудитын арга зүй, мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх сургалтын материал боловсруулах;
- Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах түвшин тогтоо болон бусад шалгалтын материал, тест боловсруулах;
- Хууль тогтоомжоор хүлээсэн ба Ерөнхий аудитороос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу гүйцэтгэх бусад ажил үүрэг.

Бодлого, төлөвлөлтийн газар нь Аудитын стандарт, арга зүйн болон Төлөвлөлт, судалгааны 2 албатай байна.

-- оОо --

Монгол Улсын Ерөнхий Аудиторын
2017 оны дугаар сарын 22-ны
өдрийн дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ОРОН ТОО,
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

УХА0122

№	Албан тушаалын нэр	Орон тоо
	Удирдлага	5
1	Монгол Улсын Ерөнхий Аудитор	1
2	Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор	2
3	Ерөнхий Аудиторын зөвлөх	1
4	Тамгын газрын дарга	1
	Дотоод аудит, чанарын баталгаажуулалтын алба	5
5	Албаны дарга бөгөөд тэргүүлэх аудитор	1
6	Дотоод аудитор аудитын менежер	1
7	Чанарын баталгаажуулалтын аудитын менежер	1
8	Чанарын баталгаажуулалтын ахлах аудитор	2
	Ерөнхий аудиторын (төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагыг хариуцсан) орлогчийн харьяанд ажиллах бүтцийн нэгжүүд	7
9	Менежер	1
10	Сургалт хөгжүүлэлтийн төвийн дарга	1
11	Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч	1
12	Мониторинг үнэлгээ хариуцсан ахлах шинжээч	1
13	Стратеги, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	1
14	Нягтлан бодогч	1
15	Сургалтын мэргэжилтэн	1
	Тамгын газар	16
16	Хүний нөөцийн менежер	1
17	Нийтлэг үйлчилгээний албаны менежер	1
18	Мэдээллийн технологийн албаны менежер	1
19	Ахлах нягтлан бодогч	1
20	Хүний нөөцийн мэргэжилтэн	2
21	Мэдээллийн технологийн албаны мэргэжилтэн	2
22	Гадаад харилцааны мэргэжилтэн	1
23	Олон нийт, хэвлэл мэдээллийн ажилтан	1
24	Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн	1
25	Эд хариуцагч бөгөөд архивын ажилтан	1
26	Бичиг хэргийн ажилтан	1
27	Ерөнхий аудиторын туслах	1
28	Жолооч	2
	Гүйцэтгэлийн аудитын газар	25
29	Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	1
30	Аудитын менежер	2
31	Ахлах аудитор	5
32	Аудитор	17
	Санхүүгийн аудитын газар	27
33	Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	1
34	Аудитын менежер	3
35	Ахлах аудитор	5
36	Аудитор	18
	Нийцлийн аудитын газар	9
37	Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	1
38	Аудитын менежер	1

39	Ахлах аудитор	2
40	Аудитор	5
	Бодлого, төлөвлөлтийн газар	6
41	Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	1
42	Арга зүйч аудитын менежер	3
43	Судлаач аудитын менежер	1
44	Судлаач шинжээч	1
	Хууль, эрх зүйн хэлтэс	3
45	Хэлтсийн дарга	1
46	Хуульч шинжээч	2
	Бүгд	103